ОРОС ХЭЛНЭЭС ОРЧУУЛСАН МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ ЭРТ ЦАГИЙН НЭГЭН БҮТЭЭЛИЙГ НЭХЭН СУДЛАХУЙ

Академич Шаравын Болд
Монголын Анагаах Ухааны Академи
E-mail: boldshrv@gmail.com

Abstract

A REVIEW OF AN ANCIENT BOOK OF MONGOLIAN MEDICINE TRANSLATED FROM RUSSIAN

Academician Bold Sharavyn
Mongolian Academy of Medical Sciences
E-mail: boldshrv@gmail.com

In our research article published in the Journal of Mongolian Medical Science, 2018 №1 (183), we made the following conclusion.

1. Activities of religious envoys from Europe to the Qing dynasty (Manchu) and Mongolia, the Imperial Russian Consular office, which was opened in Ikh Khuree (The ancient capital of Mongolia), and documents related to infectious diseases, European medical knowledge and information on medical care are historical facts that European medicine was first “imported” to Mongolia. Based on these facts, the knowledge of European medicine in Mongolia began to spread in the 1720s.
2. It was concluded that the knowledge of European medicine in Mongolia had previously been concentrated in Ikh Khuree through the Qing dynasty (Manchu), Inner Mongolia, and Buryatia in the north, and had gradually spread to some provinces of Mongolia to prevent communicable diseases.

Over the next three years, many pieces of evidence were found that enriched the history of Mongolian medicine. Among these facts, a book called in the Oirat dialect “Ahr surhl” is of great interest as the book provides an opportunity to further confirm that European medicine has begun to spread in Mongolia, as we noted in a previous article.

The Russian title of the book is “ Краткое наставление о лечении болезней простыми средствами” and the Mongolian translation in English is “A Brief treatise” (A Brief Instruction on Treating Diseases with Simple Methods). The book is called “Ahr surhl” when translated from Russian into Oirat dialects in Todo Bichig (Clear Script).

The first volume was compiled by Professor Osip Kirillovich Kamenetsky, the first Russian physician and member of the Academy of Medicine and Surgery, and the second volume was compiled by Yakov Osipovich Sapolovich and published in St. Petersburg in 1803. Later, with the help of Princess Tseveg Tundutova of Kalmykia, Nikolay Alekseevich Lebedev translated the Oirat dialect into Todo Bichig (Clear Script).

The book is one of the historical sources that clarifies how European medicine spread through Russia in the late 18th and early 19th centuries, and how European medicine and traditional medicine coexisted and developed. It is a brief book compiled by a Russian scholar on the medical knowledge, methods, and pharmacology in European medicine.

It is important to note that the translation of this book in the Oirat dialect into Todo Bichig (Clear Script) opened the door for the Mongolian people to use European medicine. Therefore, it is true that the knowledge of Western medicine began to spread among the Mongols as early as the 19th century. The only book currently preserved in Mongolia was found in Khuvsgul province in north, not in the Oirat-speaking western provinces of Mongolia. This is a testament to the book’s widespread popularity in Mongolia.

Keywords: European medicine, spread, Mongolia, historical sources, Oirat dialect, Todo Bichig

Оршил

Монголчуудын өвөг дээдэс хүний оюун ухаан, гараар бүтээгдсэн соёл иргэншлийн өвөрмөц хэлбэр нүүдлийн соёл иргэншлийг бүтээж, үеэс үед уламжлуулахдаа өөрийн гэсэн онцлогтой, шинжлэх ухаанаар бүрэн дүүрэн нотлогдоогүй ч практикаар шалгагдсан домнон засах аргыг бий болгон хөгжүүлсээр өнөөг хүргэн иржээ. Энэхүү домын арга нь эхний үед амаар дамжин хэрэглэгдэж байгаад Согдоос гаралтай уйгар бичигт үндэслэсэн монгол бичгээр болон тод монголоор бичигдэн гар бичмэлээр тархсан байна. Үүний зэрэгцээ төвөд хэлээр бичсэн дан домын болон бурхны шашны зан үйлтэй нийцүүлсэн домын бэсрэг судрууд ч цөөнгүй олдож байна.

Дом заслын арга нь Монголын уламжлалт анагаах ухааны суурь мэдлэг, нүүдлийн соёлтой нягт уялдсан, цаашид нарийвчлан судалж нотолгоожуулах шаардлагатай ухааны нэг юм. Гэхдээ нотолгоожсон эмчилгээний аргууд ч багагүй байх бөгөөд Сүмбэ хамба Ишбалжирын “Дөрвөн рашаан”-д, Өргөөгийн Мамба дацангийн хэсэг лам эмч, маарамба нар хамтран бүтээсэн гэдэг Чоймпил тойны “Нандин эрдэнийн шимийн хураангуй” сударт монгол домын аргуудыг түүвэрлэн авч оруулсан байдаг.

Үүний зэрэгцээ эртний монгол мэргэд санскрит, төвөд, манж, хятад, уйгар, орос хэлнээс анагаан засах аргатай холбоотой ном судрыг орчуулан бүтээлчээр ашиглаж байв. Эдгээр хэлнээс орчуулсан анагаах ухааны бүтээлүүдээс хамгийн бага судлагдсан нь уйгар, орос хэлнээс орчуулсан номууд юм.

Уйгар хэлнээс орчуулсан номын хувьд одоогоор мэдэгдэж байгаагаас 1328 онд гүүш Шаравсэнгэ ламын уйгар, төвөд хэлнээс орчуулсан Бурхан багшийн үеийн зохиол “Алтангэрэл” судрын 24 дүгээр бүлэгт эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны вата, питта, капа онолын хэсгийг оруулсан байдаг [1]. Хэдийгээр 29 болон 31 бүлэгтэй уг сударт анагаах ухааны талаар нэг бүлэг орсон байгаа боловч ач холбогдлын хувьд нэн чухал мэдээлэл агуулсныг судалгаагаар тодруулжээ [2].

Харин орос хэлнээс орчуулсан анагаах ухааны эртний бүтээлийн тухай хийсэн судалгаа, бат нот баримтад тулгуурласан эрдэм шинжилгээний өгүүлэл “Европын анагаах ухаан Монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь” бүтээлээс өөр ямар нэгэн судалгааны ажил олдохгүй байна [3].

Бид SCOPUS, PubMed, Web of Science зэрэг мэдээллийн эх сурвалжуудад байгаа судалгааны өгүүллүүдээс хайлт хийсний зэрэгцээ, Монгол Улсад албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн анагаах ухааны 16 сэтгүүлээс хайлт хийж үзэв. Ямар нэгэн илрэц гарч ирсэнгүй.

Монголын уламжлалт анагаах ухаан бол албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоо, энэхүү тогтолцоо нь хөгжлийн явцад Монголчуудын соёлын томоохон хэсэг болж, бусад орны анагаах ухааны мэдлэгээр баяжигдсаар ирсэн байна [4]. Бусад орны гэдэгт Энэтхэг, Төвөд, Хятадын анагаах ухаанаас гадна төдийлөн судлагдаагүй байгаа Европын анагаах ухааны чухал бүрэлдхүүн хэсэг Оросын анагаах ухааны эрт үеийн номууд орох бөгөөд ямар зохиол байсан, ямар зохиолыг монгол хэлээр орчуулж байсан түүхийг судлах, эх сурвалжийг судалгааны эргэлтэд оруулахаар энэхүү судалгааг хийлээ.

1. Европын анагаах ухааны дэлгэрлийн эхлэлийг шинэчлэхүй

Бид өмнө нь хэвлэгдсэн өгүүлэлдээ [5] Европын анагаах ухаан Монгол үндэстэний дотор хэзээ дэлгэрснийг дараах баримтуудаар нотлох гэж оролдсон юм. Үүнд:

1. “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээл Европын анатомийн бүтээлүүдэд суурилсан Өрнө-Дорны анагаах ухааны мэдлэгийг харгалдуулан бичсэн ховор ном бөгөөд Монголд Европын анагаах ухаан хүний биеийн бүтэц зүйн бүтээлээр дамжин дэлгэрч байсны гэрч хэмээн үзэх үндэстэй болно хэмээн тэмдэглэж байсан. Тухайлбал 1687 онд Манжийн Энх-Амгалан (1662-1722 он) хааны засаглалын үеэр Францын Есүсийн нийгэмлэгийн гишүүдийн анхны элч нар болох Жоаким Бүвет (1656-1730), Лөүс ЛеСомт (1655-1728), Клод де Висделоу (1656-1737), Жан де Фонтаней (1643-1710), Жан-Франсуа Гербиллон (1654-1707) нар Манж Чин улсад иржээ. Энэ таваас Бүвет, Гербиллон нар Бээжин хотод үлдэхээр сонгогдов. Бээжинд үлдсэн 2 удалгүй эзэн хааны итгэлийг олж, арифметик, Эвклидийн

элементүүд, практик геометр болон философи зэрэг Европын мэдлэг, ухааныг заан сургах багш нар нь болсон байна. Манжийн эзэн хаан таван жилийн туршид дээрх мэдлэгээс суралцаж байгаад 1692 онд 40 настай байхдаа хумхаа буюу чичрэг өвчнөөр өвджээ. Шашны элч нарын хяналт сайтай, үр дүнтэй эмчилгээний дараа эзэн хааны амь нас аврагдаж, энэ мэдээг олон түмэнд зарлаж, хааны ордны доторх том харшаар тэднийг шагнав. Барууны анагаах ухаанаас үр шимийг нь хүртсэн Энх-Амгалан хаан гадаадын шинжлэх ухааныг ихэд сонирхож байв. Тэрбээр Бүветэд анатомийн тухай анагаах ухааны бүтээл бэлтгэхийг тушаасан байна. Улмаар төд удалгүй хаанд анатоми зааж эхлэв. Гэвч хэсэг хугацааны дараа Бүвет Франц руу явах болсон тул анатомийн хичээл заах ажил түр зогсчээ. 1698 онд Манжид ирсэн Доминик Пареннин (1665-1741) хэмээх өөр нэг элч уг ажлыг үргэлжлүүлэн дуусгасан байна. Тэрбээр орчуулагч төдийгүй математикч хүн байлаа. Шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийн талаарх эзэн хааны асуултад тун ч тодорхой, ухаалаг, сургамжтай хариулт өгдөг байснаараа тухайн үеийн судлаачдаас ялгардаг байжээ. Пареннин хүний биеийн бүтцийн талаарх мэдээллийг үргэлжлүүлэн цуглуулж анатомийн бүтээл бичиж эхлэв. Тэрбээр бүтээлдээ Пиер Дионисийн бичсэн тэр үедээ хамгийн нарийн, тодорхой бичигдсэн гэгддэг Европт анатомийн стандарт бүтээлүүдийн нэг байсан номыг сонгон авчээ. Харин жишээ зургийн хувьд Данийн Томас Бартолинийн номыг илүүд үзжээ. Анатомийн номыг таван жил бичсэн бөгөөд энэ хугацаанд эзэн хаан гурван хятадач, хоёр бичээч, хоёр зураач гарган өгч туслуулав. Уг бүтээл дууссаны дараа эзэн хаан хэвлэх зөвшөөрөл өгөхөөс татгалзав. Учир нь энэ бүтээл нь сайн боловсроогүй, шинэ зүйлийг хүлээн авах цаг нь болоогүй хүмүүсийн үзэж судлах энгийн нэг ном биш хэмээн үзсэн байна. Тэр ч бүү хэл гар бичмэлийг нь унших эрхийг хэдхэн хүмүүст олгон, тэдэнд номыг ордноос авч гарах, эсвэл тэмдэглэл хөтлөх зөвшөөрөл олгохгүй байв. Нийт гурван хуулбарыг гараар бичиж, Бээжин хотод нэг, нийслэлээс гаднах Цэнгэлдэх ордонд нэг, гурав дахийг нь Манжийн өвөг дээдсийн нутаг Жехолд тус тус хадгалжээ. Харин Пареннин нэгэн тусгай хуулбарыг хийн өөрийн гишүүн байсан Парис дахь Шинжлэх Ухааны Академид илгээжээ. Парисын хуулбар нь олон зууны турш Европт байгаа цорын ганц хуулбар юм. Европт уг номыг “Манж анатоми” хэмээн алдаршуулж, олон арван судалгааны бүтээл хэвлүүлсэн байдаг. Ер бусын сэтгэдэг, шинжлэх ухаанд дур сонирхолтой Энх-Амгалан хаан урлаг, шинжлэх ухааныг хөхиүлэн дэмждэг байсан ч “Манж анатоми”-ийн ач холбогдлыг төдийлөн ойлгож чадаагүйгээс уг номыг хэвлүүлээгүй хэмээн үздэг. Хэрэв хаан уг номыг хэвлүүлэн түгээсэн бол Европын анагаах ухаанд Везалийн “Фабрика” [6] (1543) хэмээх анатомийн ном хувьсгал хийсэнтэй адил тухайн үедээ Манж, Хятад, Монголын анагаах ухаанд хувьсгал хийх байжээ.

2. Москвагаас Их Хүрээгээр дамжин, Бээжин рүү явж буй ван Головиныг дагалдан явж байсан Рейман эмч 1811 онд Монголд анх иржээ. Головин ван эмчийн хамт Их Хүрээнд түр саатан, орос ажилчид, зарим ноёд, түшмэдийг үзэж зөвлөгөө өгсөн байна. Энэ баримт Өргөөд гадаадын эмч үзлэг хийсэн тухай одоогоор олдоод байгаа эрт үеийн мэдээ хэмээн үзэж болохоор байна.


3. Монгол үндэстэнд Европ эмнэлгийн тусламжийг үзүүлж байсан өөр нэг нотолгоо нь шашин номлогч, элч Эдвард Сталлибрасс (1793-1884) түүний нөхөд юм. Тэрбээр анхны эхнэр Сара Робинсон Сталлибрассын хамт 1818 оны 3 дугаар сарын 30-нд Эрхүүд очиж Сэлэнгийн буриадуудтай уулзжээ. Гэвч тэд буриадуудтай хэл нэвтэрч төлийлөн чадаагүй байна. Учир нь Эдвард Сталлибрасс болон эхнэр Сара нарын монгол хэлний дуудлага маш ойлгомжгүй байж. Удалгүй Сара өвдөж буцсан бөгөөд өөр хэдэн элч нар ирж тэд хамтран 1820 онд Сэлэнгэд очиж өөрсдийн үйл ажиллагаагаа явуулжээ. Тэд нүүдэлчин буриад айлаар орж шашны номлолыг ухуулахын зэрэгцээ эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байв.

Бид өмнөх өгүүлэлдээ дээрх 3 үндэслэлийг гаргаад цааш нь “Европын анагаах ухаан Монгол оронд анх “импортлогдсон” түүхэн баримтууд, Манж Чин гүрний хаан Энх-Амгалан түүний бодлого, Европоос Манжид болон Монголд ирсэн шашны элч нарын үйл ажиллагаа, Хаант Оросын Консулын газар Өргөөд нээгдсэн үйл хэрэг, халдварт өвчтэй холбоотой баримт бичгүүдэд тулгуурлан Европын

анагаах ухааны мэдлэг, эмнэлгийн тусламж Монголд дэлгэрч байсныг тодруулахыг зорьж, дээрх баримтуудад үндэслэн Европ зүгийн анагаах ухааны мэдлэг 1723 оноос эхлэн дэлгэрэх үндсээ тавьжээ. Энэ мэдлэг урьд зүгээс Бээжин, Өвөр Монголоор, Хойд талаас Буриадаар дамжин Их Хүрээнд төвлөрөн улмаар зарим аймаг хошуунд халдварт өвчнөөс сэргийлэх хэлбэрээр аажим дэлгэрчээ" [7] гэсэн дүгнэлт хийж байсан. Түүнчлэн энэхүү өгүүлэлд Москвагаас Их Хүрээгээр дамжин, Бээжин рүү явсан ван Головиныг дагалдан явж байсан Рейман эмч 1811 онд Монголд анх ирж Их Хүрээнд түр саатан, орос ажилчид, зарим ноёд түшмэдийг үзэж зөвлөгөө өгсөн баримт нь Өргөөд гадаадын эмч үзлэг хийсэн тухай одоогоор олдоод байгаа эрт үеийн мэдээ юм гэж дурдсан нь буй.

Аливаа мэдлэгийн тархан дэлгэрэх гол эх сурвалж нь судар ном түүнийг дагасан сургалт байдаг. Монголд Буддын шашин шарын шашны хэлбэрээр дэлгэрэхдээ мөн л энэ ёсыг дагасан. Тухайлбал XVI зууны сүүлчээр буюу түүнээс хойш Ширээт гүүш "Юмжайвэрэн дүйсүм"-ийг монгол хэлэнд орчуулсанаас эхлэн Монгол оронд Бурхны шашин газар, зүг бүхэнд дэлгэрэн шашны мэдлэг, ухааны олон салбарын цогц бүтээлүүдийг манай эрдэмтэд судлан, зарим гол бүтээлүүдийг монгол хэлээр орчуулах, өөрсдөө тайлбар бичих, шинээр туурвих зэргээр олон зуун бүтээлийг цогцлоон бий болгон, сургалтын бие даасан тогтолцоог бүрдүүлсэн. Энэ удаа бидний судалгаанд авсан орос хэлнээс орчуулсан анагаах ухааны ном ч мөн л дээрх замаар тархах боломжтой байсан. Харамсалтай нь уг бүтээл нэг талаас Бурхны шашны мэдлэгтэй холбоогүй нөгөө талаас Монгол орныг хараандаа оруулж шашныг бүх талаар дэмжин дэлгэрүүлж түүний тусламжтайгаар ард олныг мунхруулан харанхуй бүдүүлэг хэвээр нь барьж, номхон боол болгох гэсэн Манжийн төрийн бодлогын харгайгаар Өрнийн мэдлэг ухаан дэлгэрэх үүдийг хаасан байв.

Бид "Европын анагаах ухаан Монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь" гэсэн өгүүллээ 2018 онд хэвлүүлж байсан. Түүнээс хойших 3 жилийн хугацаанд Монголын анагаах ухааны түүхийг баяжуулсан шинээр хэд хэдэн материал олж судалгаанд хамруулав. Эдгээр материалын дотроос "Ахархан сургаал" хэмээх нэгэн ном ихээхэн анхаарал татаж байна (Зураг 1).



Зураг 1. Нямаа овогтой Дашгавжэд 1960 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр "Ахархан сургаал" номыг Үндэсний номын санд хүлээн өгсөн тэмдэглэл

Энэ номыг Хөвсгөл аймгийн Рашаант сумын нэгдүгээр бригадын Нямаа овогтой Дашгавжэд 1960 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Үндэсний номын санд хүлээлгэн өгсөн бөгөөд энэ тухай тэмдэглэлийг монгол бичгээр үйлдэж номын арын 155 дугаар хуудсанд тусгайлан наажээ. [8]. Энэ ном бидний өмнөх өгүүлэлдээ тэмдэглэсэн Монголд Европын анагаах ухааны мэдлэг дэлгэрэх эхлэлээ тавьсан гэсэн баримтыг улам бататгах боломжийг олгож байна. Өөрөөр хэлбэл Европын анагаах ухаан Оросоор дамжин 18 дугаар зууны сүүлч 19 дүгээр зууны эхэнд дэлгэрчээ. Үүнийг хэрхэн баталгаажуулсныг дараах баримтуудаас үзье.

2. "Ахархан сургаал" номын уг гарвал

Орос хэлээр: "Краткое наставление о лечении болезней простыми средствами". Нэмж зассан 4 дэх хэвлэл. Санкт Петербург, Эмнэлгийн хэвлэл, 1811 он.

Монгол хэлээр (Ойрад аялгуугаар тод үсгээр): “Ахархан сургаал” буюу “Өвчтэй хүүг хямд аргаар эмнэх зүй” гэсэн ном.

Х.Лувсанбалдан 1975 онд бичсэн “Тод үсэг, түүний дурсгалууд” бүтээлдээ “Хуучин бичиг дурсгалын зүйлд орос хэлнээс орчуулсан ном маш ховор юм. 1960 онд Хөвсгөл аймгийн Рашаант сумаас 153 хуудастай нэгэн дармал номыг Улсын нийтийн номын сангийн ажилтнууд олж авчээ. Энэ ном нь “Ахархан сургаал” гэдэг нэртэй, хүүхдийн өвчнийг анагаах тухай ном байв.

Нэгдүгээр дэвтэр нь 217 бүлэгтэй, хоёрдугаар дэвтэр нь 84 бүлэгтэй. Энэ хоёр дэвтэрт өвчний шинж тэмдэг, тэр өвчин ямар шалтгаанаар үүсэх, хэрхэн эмчлэх тухай тодорхой дурджээ. Мөнхүү хоёр дэвтрийн хавсралт болгож эмийн ургамлын орос, монгол хадмал нэрийг ард нь жагсаасан байна. Энэ номыг Иосиф Камнечук гэгч зохиож “Титуларный советник болоод квалер Микулай Лебедев” гэдэг хүн орчуулж хэвлэн гаргасан байна. Европ зүгийн анагаах ухааны номыг монгол хэлнээ орчуулсны анх нь энэхүү “Ахархан сургаал” байж ч магадгүй” гэжээ [9].

Гэвч энэ номыг анагаах ухааны талаас нь цаашид хэн нэгэн нь гүнзгийрүүлж судлахгүй байсаар 21 дүгээр зууны эхэнтэй золгов.

Бид энэхүү номыг тод монгол үсгээс кирилл үсгэнд бүрэн эхээр нь буулгаж, 1803, 1805, 1811, 1864 оны орос хэвлэлийг нь олж аван харьцуулан судалгаанд хамруулав. Х.Лувсанбалдан “Ахархан сургаал” номын төгсгөлд бичсэн “өвчтэй хүүг хямд аргаар эмнэх зүй” гэдгийг нь уншаад хүүхдийн өвчнийг анагаах тухай ном гэж үзжээ. Бид ч судалгаагаа эхлэхээс өмнө уг номыг олж аваагүй үедээ хүүхдийн өвчний ном хэмээн бодож, ярьж явсан. Гэвч нарийвчлан судалвал энд дурдаад байгаа хүү гэдэг нь ямар нэгэн бага балчир хүүг хэлж байгаа бус харин бага залуу хүн, насанд хүрсэн гэзэг тавьсан залуу буюу ерөнхийдөө хүн гэдэг утгаар нь хэлсэн бололтой. Үүнийг батлах өөр нэгэн баримт бол “Монголын нууц товчоо”-д “кү’ү алтапа” гэсэн үг бий. Кү’ү гэдэг нь өнөө цагийн аялгаар хүн гэсэн утгатай үг ажээ. Энэ бүгдэд үндэслэвэл “өвчтэй хүүг хямд аргаар эмнэх зүй” гэдгийг “өвчтэй хүнийг хямд аргаар эмнэх зүй” гэж ойлговол зохих юм.


Нөгөө талаар номын 5 дугаар хуудсанд: Эхэн дэвтэрт нийт хүүхэд хүмүүнд болон нялх балчир хүүхдэд дотор нь буугч гэмийн зүй цайлгаж сургамжийн бичигт гэмтэй хүүг эхэнд ямархан хэвээр1 эмнэн өвчинг ялгаж мэдэгдэхээс урд гэмт хүүг ямархан хэвээр асран өгч хойно нь заасан боловч ондоо нь нийтэд бичигдсэн буй” гэжээ [10]. Өрөөр хэлбэл уг ном нь эмч байхгүй алслагдсан газрын хүмүүст (хүүхэд, хүмүүн, нялх балчир хүүхэд аль аль нь орно) зориулагдсан, хүртээмжтэй, тохиромжтой хэлбэрээр эм бэлтгэх, хэрхэн хэрэглэх талаар зөвлөгөө, зааварчилгаа өгсөн, түүнчлэн өвчний шинж тэмдэг, явцын талаар товч тайлбарласан бүтээл болно.

Тиймээс энэ ном дан ганц хүүхдийн өвчний ном биш хэмээн үзэж байна. Энэ номонд зонхилон тохиолдох өвчин, халдварт өвчин, эх барих, эмэгтэйчүүдийн өвчин, балчир хүүхэд, нялхасын гэм гээд төрөл бүрийн өвчний талаар тусгайлан тэмдэглэсэн байна. Номын орос нэрийг “Краткое наставление о лечении болезней простыми средствами” [11] гэх бөгөөд монголоор орчуулбал “Энгийн аргаар өвчин эмчлэх тухай товч заавар” гэж бууж байна. Харин уг номыг орос хэлнээс ойрад аялгуугаар тод үсгэнд орчуулахдаа “Ахар сургаал” (Ahr surhl) “Ахархан сургаал” гэж нэрлэжээ.

“Ахархан сургаал” хэмээн тод үсгээр орчуулсан энэхүү номыг Стародубын уугуул, Оросын анхны эмч, Анагаах ухаан, мэс заслын академийн мэс заслын гишүүн, профессор Осип Кириллович Каменецкий, Анагаах ухааны коллежийн нэрийн өмнөөс “Краткое наставление о лечении болезней простыми средствами” (Энгийн аргаар өвчин эмчлэх тухай товч заавар)-ыг эмхэтгэн Санкт-Петербург хотноо 1803 онд анх хэвлүүлжээ. Энэ бүтээлийн хоёрдугаар дэвтрийг Яков Осипович Саполович эмхэтгэсэн байна.

1 Ямархан хэвээр – хэр хэмжээгээр


Осип Кириллович Каменецкий гэж хэн бэ?



Каменецкий Осип Кириллович 1754 онд Стародуб хотод төрсөн. Бага наснаасаа эхлэн өвчтэй хүмүүст туслахыг мөрөөддөг, хүмүүсийг үхлээс аварч, тэдний эрүүл мэндийг хамгаалах чин хүсэлтэй хүүхэд байв. Тэрбээр 24 настайдаа Санкт-Петербургийн нэгдсэн эмнэлэгт суралцахаар элсэн орж, сургуулиа төгсөөд Невскийн цэргийн эмнэлэгт туслах эмчээр томилогдов. Осип Кириллович Швед, Туркийн эсрэг хэд хэдэн удаагийн тулалдаанд цэргийн эмчээр оролцохдоо дайны хүнд зовлон зүдгүүрийг туулжээ. Шархадсан хүмүүс сайн эмчийг шүтдэг байв. Тэд Каменецкийн тухай “Өөрөө шархдсан юм шиг шарханд зөөлөн хүрдэг” хэмээн хэлэлцдэг байжээ. Энэ нь гайхах зүйл биш бөгөөд Осип Кирилловичийн эдгээр энгийн цэргүүдийг хайрлах, өрөвдөх нинжин сэтгэл түүний бага насанд тогтсонтой холбоотой юм. Тэрбээр дайны дараа өөрийн олж авсан туршлагаа бусадтай хуваалцахыг хүсч улмаар 1802 онд теологийн2 семинарт анагаах ухааныг заах тухай эзэн хааны зарлиг гарахад сурах бичиг бичиж эхлэв. Дараа жил нь буюу 1803 онд Каменецкийн “Энгийн аргаар өвчин эмчлэх тухай товч заавар” гэсэн гарчигтай ном хэвлэгдсэн байна (Зураг 2). Осип Каменецкий бол Оросын анхны эмч, өөрөөр хэлбэл эзэн хааны ордны эмч байв. Түүнээс өмнө энэ албан тушаалд зөвхөн гадаадын эмч нар томилогддог байжээ. Үүнээс гадна Осип Кириллович буяны үйлсээрээ алдартай байсан. Тухайлбал нийгмийн байдлаас үл хамааран эмнэлгийн тусламж хэрэгтэй хүмүүсийг үнэ төлбөргүй эмчилдэг, заримдаа зуны амралтаараа хөдөө тосгонд очиж энгийн иргэдэд төлбөргүй тусламж үзүүлдэг байв.

Каменецкийн хүмүүсийн эрүүл мэндийн талаар санаа нь зовж байсан асуудлын дотроос тосгоны оршин суугчдын өвчлөл нь ихэвчлэн гэр бүлийн хүрээнд, олон хүнтэй нэг газар амьдардаг гэр бүл, гэр бүлийн гадаад орчны бохирдол, эмх замбараагүй байдал, байшингийн чийглэг, давчуу байдал, мал сүргээ гэрийн ойролцоо байлгах, эсхүл чийгтэй ой, намгархаг газарт байшин барьсан ч агааржуулалт муу, агаарын солилцоо сайн биш зэрэг нь ихээхэн анхаарал татаж байв. Үүний зэрэгцээ тэрбээр сайн чанарын цэвэр усаар хангагдаагүй, хүнсний нөөц хомсдсон газар, намаг гэх мэт газарт байрлах, исгэлэн, ялзарсан, боловсорч амжаагүй жимс, мөөг, тослог хоолыг хэтрүүлэн хэрэглэх, хүйтэн ундаа уух, зуны улиралд халах, хүйтэнд даарах, салхи үлээх, эсвэл унтаж байх үед нарны хэт ягаан туяа биед тусах зэрэг нь эрүүл мэндэд сөрөг болон аюултай байдгийг сайн ойлгож авчээ. Мөн унтсаны дараа халуун пийшин дээр хөөрч, намар, өвлийн улиралд зөвхөн цамцтай, гуталгүй хашаандаа явах, удаан хугацаагаар ажил хийснийхээ дараа ваннд угаалга хийдэггүй үүнээс болж арьсны гадаргуу нь ердийн хөлрөх чадваргүй болох гэх мэт нөхцөл байдлуудаас өвчин үүсдэгийг судлан тогтоожээ. О.К.Каменецкий энэ мэтчилэн өвчний шалтгаан, нөхцөл, шинж тэмдгийг тодруулахын хажуугаар өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дагаж мөрдөхгүй байснаар өвчинд хэрхэн өртөмтгий болохыг нь олж мэдэв. Ингээд ард иргэдэд зориулан “Краткое наставление о лечении болезней простыми средствами” номыг Яков Осипович Саполовичтэй хамтран эмхэтгэсэн байна [12].

2 Теологи нь шашны итгэл үнэмшил, зан үйл, туршлагыг судалдаг салбар.



КРАТКОЕ НАСТАВЛЕНІЕ
О
ЛѢЧЕНІИ БОЛѢЗНЕЙ ПРОСТЫМИ
СРЕДСТВАМИ.

ПО ВЫСОЧАЙШЕМУ ПОВЕЛѢНІЮ
ИЗДАННОЕ.

ЧАСТЬ ПЕРВАЯ.

По препорученію Государственной Медицинской Коллегіи сочинена, оной Коллегіи Членомъ Осипомъ Каменецкимъ и съ одобренія Коллегіи напечатана.

ВЪ САНКТПЕТЕРБУРГѢ,
ВЪ Типографіи Государственной Медицинской Коллегіи 1803 года.

Зураг 2. “Краткое наставление о лечении болезней простыми средствами” буюу товчоор “Ахархан сургаал” номын 1803 оны хэвлэл

Тэрбээр Анагаах ухаан, мэс заслын академийн мэс заслын гишүүн, профессор хүн байсан төдийгүй түүнд 1814 онд ямар нэгэн шалгалтгүйгээр (хамгаалалт хийлгүй) анагаах ухааны докторын зэрэг олгожээ. Үүний дараа 1817 онд О.К.Каменецкийг Оросын ШУА-ийн хүндэт гишүүнээр сонгосон. Каменецкий Осип Кирилловичийн эмхэтгэсэн “Энгийн аргаар өвчин эмчлэх тухай товч заавар” номыг 1803-1864 он хүртэл 9 удаа хэвлэсэн. Энэ бүтээлээс гадна “Хордлогын улмаас үүссэн өвчнийг эмчлэх товч заавар”, “Эмч байхгүй үед өвчтөнийг эмчлэх заавар”-ыг тус тус хэвлүүлжээ.


Яков Осипович Саполович

Саполович (Яков Осипович) мэс заслын профессор. 1778 онд Кронштадтын Адмиралти эмнэлэгт, нэг жилийн дараа Санкт-Петербургт, 1783 онд эмч, задлан хийгч, удалгүй Кронштадтын Адмиралти эмнэлгийн оператор, 1790 онд Санкт-Петербургийн Анагаах ухаан-мэс заслын сургуулийн эмнэлэгт мэс заслын профессор, онолын болон мэс заслын эмчээр томилогджээ. 1785 онд чулуу авах гурван хагалгааг амжилттай хийсэн гэдэг. Түүнчлэн Я.С.Саполович нь улсын анагаах ухааны коллежийн гишүүн байсан бөгөөд Санкт-Петербургийн багаж хэрэгслийн үйлдвэрийг хариуцан ажиллаж байв. Тэрбээр 1814 онд ямар нэгэн шалгалтгүйгээр анагаах ухаан, мэс заслын докторын зэрэг хамгаалжээ. Үүний дараа Санкт-Петербургийн Анагаах ухаан, мэс заслын сургуулиас өөрчлөн байгуулагдсан Анагаах ухаан, мэс заслын академийн гишүүн болсон. Я.С.Саполович нь Каменецкий Осип Кирилловичийн хамт “Энгийн аргаар өвчнийг эмчлэх товч заавар”-ын хоёрдугаар дэвтрийг эмхэтгэн Санкт-Петербург хотод 1803 онд анх хэвлүүлжээ.

“Ахархан сургаал” номын монгол орчуулга

“Ахархан сургаал” номын төгсгөлийн үгэнд: (Ахр сурhль. Өвчте кууг кимд арhар эмин зуу. Деед төд ик эзнэ гегэнэ ишэр hарhсн 1 - гч дегтр. Эмин зууhиин коллег даалhсар эмин зууд бээгч эмч Осип Каменецкий эн бичг бийнь hарhва. Уунэс хальмгин келнд орчулва Титулярный советник, кавалер Николай Лебедев)

Кирилл үсгэнд: “Ахархан сургаал, өвчтэй хүүг хямд аргаар эмнэх зүй. Дээд төд их эзний гэгээний эшээр гаргасан нэгдүгээр дэвтэр. Эмийн зүйгийн коллеги даалгасаар эмийн зүйд байгч эмч Осип Каменецкийн энэ бичиг бичин гаргав. Үүнээс халимагийн хэлэнд орчуулав. Титулярный советник Миколай Лебедев (Николай Алексеевич Лебедев). Санта Петер Бургэд энэ орос бичиг карласан жил нь мянга найман зуун арван нэгдэгч жил” (Зураг 3) гэж буулгана [13].



Зураг 3. “Ахархан сургаал” номын төгсгөлийн 156 дугаар хуудас

Николай Алексеевич Лебедев

Николай Алексеевич Лебедев (төрсөн болон нас барсан он цаг, газар нь тодорхойгүй, ойролцоогоор 18 дугаар зууны төгсгөл 19-р зууны эхний хагаст амьдарч байсан) орчуулагч, Гадаад хэргийн зөвлөлийн 3 дугаар хэлтсийн зөвлөх албан тушаалтан, мэдлэгийн төрөл бүрийн агуулгатай танин мэдэхүйн бүтээлийг тод үсгээр орчуулсан зохиолч. Тэрбээр 19 дүгээр зууны эхээр Санкт-Петербургийн Эзэн хааны Шинжлэх Ухааны Академийн хэвлэх үйлдвэрт хэвлэгдсэн анагаах ухаан, сувилахуй, хөдөө аж ахуй, мал эмнэлгийн талаар хэд хэдэн алдартай зохиолуудыг ойрад аялгуугаар тод үсгээр орчуулсан. Николай Лебедевийн хамгийн алдартай орчуулга бол Осип Каменецкийн “Краткое наставление о лечении болезней простыми средствами” (Энгийн аргаар өвчин эмчлэх тухай товч заавар) ном юм. Түүнчлэн Н.А.Лебедев, О.К.Каменецкийн анагаах ухааны бусад бүтээлүүдийг 1806, 1822 онуудад орчуулсан. Зарим номууд тухайлбал: “Янз бүрийн хордлогын улмаас үүссэн өвчнийг энгийн аргаар эмчлэх товч заавар”, “Эмч байхгүй газарт өвчтэй хүмүүст хэрхэн тусламж үзүүлэх заавар ...” зэрэг нь Москвад хэвлэгдсэн. Тэрбээр “Бог малын цэцэг өвчний эсрэг вакцинжуулалтын тухай” товхимол, “Мал тэжээхэд баримтлах дүрэм, мал төллөх үед хэрхэн ажиллах тухай”, “Төмс тариалах товч заавар” зэрэг бүтээлийг ойрад аялгуугаар тод үсгээр орчуулжээ.

Энд нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд Халимагийн гүнж Цэвэг Тундутова (Цебек Тундутова) Н.А.Лебедевийн орчуулах ажилд тусалж байсан талаар хэд хэдэн эх сурвалж мэдээлсэн байдаг [14]. Ялангуяа гүнж Цэвэг Тундутова “Ахархан сургаал” номын доторх анагаах ухааны нэр томьёог ойрад аялгуунд орчуулах талаар Н.А.Лебедевт сэтгэл харамгүй зөвлөгөө өгч байсан хэмээн үздэг. Гүнж Цэвэг Тундутова бол Халимагийн Эрдэнэ тайш Тундутовагийн эхнэр байжээ. Эрдэнэ тайш Тундутов нь Халимагийн тал нутагт 1788 онд байгуулсан “Бага Дөрвөд Улс”-ын захирагч Чучей тайш Тундутовагийн хүү юм. Чучей тайш 1803 оны 5 дугаар сард өөрийн хүү Эрдэнэ тайшдаа захирагчийн албыг гэрээслэн нас барсан. Гэвч тухайн үеийн Оросын хаант засаг Эрдэнэ тайш Тундутовт эцгийнх нь эрх мэдлийг олгоогүй ажээ. Ямартаа ч Эрдэнэ тайш Тундутовагийн эхнэр, гүнж Цэвэг Тундутова “Ахархан сургаал” номыг орос хэлнээс орчуулахад ихээхэн туслалцаа үзүүлжээ.

“Ахархан сургаал”-ын номын бүтэц, агуулга

Николай Алексеевич Лебедевийн орос хэлнээс ойрад аялгаар тод үсгээр орчуулсан бүтээлүүд нь танин мэдэхүйн шинж чанартай зохиолууд байсан бөгөөд халимагуудыг анагаах ухаан, сувилахуй, мал тэжээврийг арчлахад болон бусад чиглэлээр сургах зорилготой байсан байна. Эдгээр бүтээлээс анагаах ухааны чиглэлээр “Ахархан сургаал” номыг 1811 оноос хойш ойрад аялуугаар тод үсгээр орчуулан хорголжин бараар дэвтэрлэж хэвлүүлжээ.

Ном бүтцийн хувьд 2 дэвтэрээс бүрдэнэ. Нэгдүгээр дэвтэр нь: 217 бүлэг, 52 (номер) хүртэл

дугаарласан эмийн зүй, хоёрдугаар дэвтэр нь: 85 бүлэг, 16 (номер) хүртэл дугаарласан эмийн зүйл, хавсралт хэсэгт: өвчний нэрүүд, эмийн нэрүүдийг халимаг-орос хэлээр бичсэн, төгсгөлийн үг бүхий нийт 155 тал бүхий ном юм [15].

Эхний дэвтэрт хижиг ханиад, эмэгтэйчүүдийн өвчин, нялхсын өвчний талаар тайлбарлаж, дараа нь зарим өвчний эхэн үед хэрхэн тусламж үзүүлэх талаар өгсөн заавар, өвчний ангилал, ямар төрлийн өвчинд хамаарах, өвчтөнийг хэрхэн эмчлэх энгийн аргуудыг тэмдэглээд ямар хоол хүнс хэрэглэх тухай ерөнхий мэдлэгийг багтаасан.

Хоёрдугаар дэвтэрт шархны зүй, өгөрлөх, цэврүүтэх шарх, хатиг, түлэгдэх, хөлдөх, амьтанд хазуулах, хамуу, усанд живэх зэрэг ийхэр шийхэр өвчний үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эм зүйн талаар тайлбарлаж, өвчний нэрийн орос, монгол нэрийн жагсаалтыг дагалдуулсан байна.

Номын өмнөх үгэнд:

- *Энэ ахархан[3] сургаал хөнгөн өвчнийг арын бяцхан балгаст харгадагаар[4] дээд их өлзийг гэгээний эшээр бичиж гаргав. Учир нь арын хол байдаг балгаст гэмт[5] хүүг түргэн эмнэх эмч үгүйн төлөө[6] арын балгаст өөрөө ч энэ аргаар эм бэлдэж чадах.*
- *Энэ сургамж бичгээр өвчний байдал болохын дээр, эмнэдэг эм тэдний балгаст эргэн өөрөө урган багцанд ч нургалж ургадаг. Зүгээр уталдсан садав[7] өвчин, гэнэтээр бүтэн харгацдаг өвчин, усан өвчин, мэрэс өвчин энэ тоот уталдсан өвчин олон ангиар зовон тусаар ч өвчин ханьцан хичээвэр хянамгай болдгийн төлөө энэ дэгтэрт[8] үл оруулагч учир нь энэ.*
- *Тэр төлөө энэ өвчнийг сайн эмчид эмнүүлэн, эмчийн санаа аван, эмчийн эмнэлэгт биеэ гүйцэс даалган эмнүүлэх зөвтэй. Энэ өвчтөнийг чармайн сайн эмч нар эндүүрээд үл мэдэн буруугаар эмнэдэг нь ч бий" гэсэн байна.*

Энэхүү бичвэрийг орос хэлээр буй "Краткое наставление о лечении болезней простыми средствами" номын өмнөх үгийн ижил мөрүүдтэй харьцуулан орчуулбал дараах утга санаа гарч байна. Үүнд:

- "Тосгоны оршин суугчдад тохиолддог энгийн өвчнийг эмчлэх, алслагдсан газарт байгаа хүмүүст түргэн тусламж үзүүлэх, тосгонд өөрсдөө хэрхэн хялбар аргаар эм бэлтгэх, эмчилгээний энгийн аргын талаар энэхүү гарын авлагад бичлээ.
- Энэхүү товч гарын авлагад яаралтай эмчлэх шаардлагатай, танихад хэцүү биш өвчний үед тосгоны ойролцоо ургадаг, эсвэл нийтийн хэрэглээнд хэрэглэдэг эмийн бодисыг хэрхэн нөөцлөх, удаан үргэлжилдэг өвчин, уушгиний сүрьеэ, амьсгал боогдох, усархаг өвчний үед (эдгээр нь үргэлжлэх олон янзын өөрчлөлтүүдтэй бусад өвчинтэй холбоотой байдаг) хэрэглэх, үл хэрэглэх дэглэмийн талаар бичсэн. Тэдгээр жорыг өвчин эмчлэхийн тулд эмч нарын зөвшөөрлийн дагуу маш болгоомжтой хэрэглэх шаардлагатай.
- Мөн сэтгэлээр унасан хүмүүст эмчийн зөвлөгөө өгөх, эсвэл эмчилгээгээ бүрэн даатгах хангалттай хугацаа байгаа тухай нэмж өгүүлнэ. Учир нь удаан чанартай архаг өвчин нь маш хүндрэлтэй байдаг ба тэр ч байтугай хамгийн сайн эмч нар заримдаа төөрөгдөлд ордог [16]" гэжээ.

Тосгон гэдгийг Халимагчуудын амьдралын хэв маягт тохируулан арын бяцхан балгас гэж буулгажээ.

---

3 Ахархан – товч, богинохон

4 Харгах – тохиолдох, уулзах


5 Гэмт – өвчтэй

6 Төлөө - тулд

7 Уталдсан садав – удааширсан саа өвчин

8 Дэгтэрт - дэвтэрт

Монголчууд нэн эртнээс төв суурин газрыг балгас, хот балгас гэж нэрлэдэг байсан. Төвлөрсөн сууриндуу газраа балгас гэж нэрлэх тохиолдол 19 зууны Халимагт байхаас гадна үүнээс өмнө, 18 дугаар зууны Төв Халхад ч байжээ. Уламжлалт анагаах ухааны гол сурах бичиг “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийг Минжүүр гүүш төвөд хэлнээс орчуулахдаа эхний үндэс “Язгуурын үндэс”-ийн нэгдгээр бүлгийн эхний хуудсанд байгаа སྒོང་ཁྱེར་ (grong khyer) гэдэг үгийг балгас гэж орчуулсан байдаг (Зураг 4).



Зураг 4. 19 дүгээр зууны үеийн Халимагийн бяцхан балгас буюу төв суурин газар

Уг нь энэ үгийн утга нь хот, жижиг хот, оршин суух газар гэсэн утгатай юм. Жишээлбэл, “Тэр балгасны өмнө зүгт Нэвтлэгч нэрт нарны хүч төгөлдөр ууланд анар, перец (хар), библин, чинжүү тэргүүтэн хүйтнийг арилгагч халуун, исгэлэн, давслаг амттай, халуун хийгээд хурц чадалтай эмийн цэцэрлэг буй” [17] гэсэн байдаг.

Ижил мөрөнд нүүж очсон Торгуудууд Оросын нөлөөгөөр суурин соёлд дасан зохицож төвлөрөн суух болж, ийм газраа бяцхан балгас гэж нэрлэдэг байжээ.

Үгсийн сангийн талаар ч уг номонд орос үг, нутгийн ярианы үг орсон байна. Жишээ нь: “Ахархан сургаал” номын 52-р талд: zolon piyiba-зөөлөн пиво, 96-р талд: stakan istakan- стакан, 98-р талд: кигiiski-кружка, 129-р талд цөөн част-цөөн цагт гэх мэт.

97-р талд “Nige stakan dabastai xayariyin suusundu xoyar uxur bal zuurchi nige-misan oruun olon elken den uuxu” гэсэн өгүүлбэр нь “Нэг стакан (орос үг) давстай хаярын (өргөст хэмх) шүүсэнд хоёр ухур (халбага) бал зуурч нэгмөсөн өрүүн (өглөө) өлөн элгэндээн уух гэж орчуулагдана [18].

Уг ном тухайн үеийн Европын анагаах ухааны өвчин зүй, эмчлэн анагаах арга, эм зүй, идээ ундааны зүйлийн талаарх мэдлэгийг орос эрдэмтний эмхэтгэсэн бэсрэг номоор дамжуулан Монгол үндэстэнд танилцуулж хэрэглэх боломжийг нээсэн хэмээн чухалчлан тэмдэглэх нь зүйтэй юм. Тиймээс Монголчуудын дунд Өрнө зүгийн анагаах ухааны мэдлэг аль эрт тухайлбал 19 дүгээр зууны эхэнд дэлгэрч эхэлсэн гэж үзэх нь үнэнд нийцнэ. Одоогоор Монгол Улсад хадгалагдаж байгаа цорын ганц ном нь Баруун аймгуудаас бус харин Хөвсгөл аймгаас олдсон нь нилээдгүй тархсаны гэрч юм.

Номын хэлний ерөнхий онцлог нь сонгодог тод үсгийн бичгийн хэлний найруулгыг баримтлалгүй халимаг ярианы хэлээр найруулсан болох нь тодорхой байна. Номын зөв бичих зүй хийгээд зарим үсгийн зурлага нь сонгодог тод үсгийн үгсийг бичих тогтсон бичлэг, үсгийн хэлбэрийг өөрөөр бичиж хэрэглэсэн зүйл мэр сэр ажиглагдаж буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл, тухайн үеийн халимаг ярианы хэлэнд нэвтэрсэн орос үгс болон орос хэлний үгсийг тэмдэглэхдээ халимаг хүмүүсийн хэрхэн дуудаж, хэлж буйг баримтлан авиачлан бичсэн бичлэгийн хэм хэмжээг тогтоож өгчээ. “Ахархан сургаал” хэмээх анагаах ухааны номын хэл найруулга, үсгийн тогтолцоо нь орчин цагийн тод үсгийн хэв маяг нэгэнт үүсэн бүрэлдсэнийг илтгэж байна. Ийм маяг нь 17 дугаар зууны үеийн албан захидлын харилцаа, хувийн бичгийн хэрэгцээнд хэрэглэгдэж эхэлсэн байдаг. Цаашид уг номыг анагаах ухааны талаас судлахаас гадна хэл найруулга, үгсийн санг орчин цагийн халимаг ярианы хэл болон ойрад аялгуутай харьцуулан судлах шаардлагатай юм.

“Ахархан сургаал” номыг яг хэдий үед хорголжин бараар хэвлэсэн гэдэг нь сонирхол татаж байна. Тод үсгийн хорголжин барыг хийхэд онцгой гавьяа байгуулсан хүн бол Яков Исаак (Яков Иванович) Шмидт юм. Я.И.Шмидт бол дорно дахины алдартай судлаач 1779 онд Амстердам хотод төрж, 1780 оноос Ижил мөрний Сарепта хотод өсч, амьдарч, худалдааны конторт ажиллан халимагуудтай худалдаа хийж байжээ. Тэрбээр энэ хугацаанд халимаг хэл сурч, уран зохиол, ардын аман зохиол, ахуй амьдрал, зан заншилтай танилцсан. 1811 онд Я.И.Шмидт Москвад суурьшиж, 1812 оны дайны үеэр Санкт-Петербург руу нүүжээ. Энд байхдаа 1815 онд “Тодо бичиг”-т тохируулан ном хэвлэх үсэг бүхий хоргожин бар цутгаж Шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэрт халимаг хэлээр орчуулагдсан шашны болон анагаах ухааны бүтээлүүдийг хэвлүүлэх ажлыг өргөжүүлжээ. Тиймээс ойрад аялгуугаар тод үсгээр “Ахархан сургаал” номыг 1815 оноос хойш мөртлөө төд удалгүй хэвлэсэн байх гэж үзэж байна. Учир нь энэ номын дараа хэвлэсэн бүтээл “Үхрийн цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх аргаар цэцэг өвчнөөс сэргийлэх заавар” товхимлыг 1846 онд хэвлүүлжээ.

“Ахархан сургаал” нь нэгэн номын хэлний хэмжээнд ч болов тухайн үеийн Ойрадын ярианы болон утга зохиолын хэлний үгсийн сан дахь эмнэлэг, эмчилгээ, өвчин, эм бэлдмэлийн нэр, хэмжил зүйн холбогдолтой нэр томьёо, түүгээр ч үл барам Европын анагаах ухаан Оросоор дамжин 18 дугаар зууны сүүлч 19 дүгээр зууны эхэнд дэлгэрч, улмаар Европийн анагаах ухаан болон уламжлалт анагаах ухаан хэрхэн зэрэгцэн оршиж, харилцан уялдаатай хөгжиж байсан тухайд ч тодруулах түүхэн эх сурвалжийн шинжтэй бүтээлийн нэг мөн хэмээн үзэж байна.

Ашигласан хэвлэл

1. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ. ADMON ХХК-ийн Хэвлэх үйлдвэр, 2006
2. Болд Ш, Цэрэнсодном Д. Монголын уламжлалт анагаах ухааны дээж бичиг. Улаанбаатар, Адмон ХК-ийн Хэвлэлийн үйлдвэр, 2013
3. Болд Ш, Болорцэцэг Ж. Европын анагаах ухаан монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь. Монголын анагаах ухаан. УБ, 2018 №1 (183)
4. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. 4 боть, УБ, 2016
5. Болд Ш, Болорцэцэг Ж. Европын анагаах ухаан монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь. Монголын анагаах ухаан. УБ, 2018 №1 (183), х.51-57
6. Андреас Везал. De humani corporis fabrica. Хүний биеийн бүтцийн 7 боть ном.
7. Болд Ш, Болорцэцэг Ж. Европын анагаах ухаан монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь. Монголын анагаах ухаан. УБ, 2018 №1 (183), х.51-57
8. “Ахархан сургаал”. Хоргожин барын тод үсгийн ном. х.156
9. Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. УБ, 1975, х.110-111
10. “Ахархан сургаал”. Хоргожин барын тод үсгийн ном. х.5
11. Краткое наставление о лечении болезней простыми средствами / Издано по высочайшему повелению. Написано по поручению мед. акад. лейб-медиком Осипом Каменецким / Пер. Н.Лебедева, - СПб., 1811
12. “Краткое наставление о лечении болезней простыми средствами”. Эмхэтгэсэн: Осип Кириллович Каменецкий, Яков Осипович Саполович. Санкпетербург, Эмнэлгийн хэвлэл. 1803
13. “Ахархан сургаал”. Хоргожин барын тод үсгийн ном
14. Ученые – исследователи Калмыкии. (XVII – начйло XX вв.). Элиста, калмыцкое книжное издаьельство, 2006, стр.122
15. “Ахархан сургаал”. Хоргожин барын тод үсгийн ном
16. “Краткое наставление о лечении болезней простыми средствами”. Нэмж зассан 4 дэх хэвлэл. Эмхэтгэсэн: Осип Кириллович Каменецкий, Яков Осипович Саполович. Санкпетербург, Эмнэлгийн хэвлэл. 1811
17. Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндэс. Монгол бичгийн модон барын судар.
18. Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. УБ, 1975, х.110-113